

ГАРЧИГ

<i>1.1 Төслийн ерөнхий мэдээлэл</i>	3
<i>1.2 Төслийн байршил</i>	3
<i>1.3 Баяжуулах үйлдвэрийн зохион байгуулалт</i>	4
<i>1.4 Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт</i>	5
<i>1.7 Баяжуулах үйлдвэрийн туслах аж ахуй</i>	8
1.7.1 Хаягдлын аж ахуй	8
1.7.2 Баяжмалын агуулах, автомашинд ачааллах систем	9
1.7.3 Засвар үйлчилгээний хэсэг	9
1.7.4 Удирдлагын өрөө	9
<i>1.8 Баяжуулах үйлдвэрийн инженер хангамж</i>	10
1.8.1 Цахилгаан хангамж	10
1.8.2 Харилцаа холбоо ба мэдээллийн хангамж	10
1.8.3 Хяналтын кабелийн систем (CCTV)	10
<i>1.9 Төслийн эдийн засгийн үр ашиг</i>	10
1.9.1 Хайлуур жоншны хэрэглээ	10
1.9.2 Хайлуур жоншны нийлүүлэлт буюу үйлдвэрлэл	11
1.9.3 Бүтээгдэхүүний үнэ	11
1.9.10 Борлуулалтын орлого	11
1.9.11 Төслийн мөнгөн урсгал, эдийн засгийн үр ашиг	12
1.9.12 Улсын төсөв орон нутгийн төсөв оруулах төлбөр, хураамж	15
1.9.13 Усны хэрэглээ зардлын тооцоо	15
1.9.14 Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц	17
1.9.15 Техник эдийн засгийн үндэслэл хэсгийн дүгнэлт	18
<i>2.1. Дожирын талбайн физик газарзүй</i>	20
<i>3.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлсэн арга зүй</i>	22
<i>3.2 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ</i>	24
<i>3.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ</i>	24
<i>3.4 Газрын хэвлийд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ</i>	26
<i>3.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ</i>	27
<i>3.6 Амьтны аймагт үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ</i>	28
<i>3.7 Нийгэм эдийн засагт нөлөөлөл нөлөөлөл, үнэлгээ</i>	29
<i>4.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго</i>	30
<i>4.1 Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө</i>	31
<i>Хүснэгт 19</i>	31
<i>4.3 Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө</i>	35
<i>4.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i> ..	36
<i>4.5 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө</i>	36
<i>4.6 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө</i>	36

4.7 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	
<i>Хүснэгт 24</i>	37
4.8 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	
<i>Хүснэгт 25</i>	39
4.9 Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	42
4.10 Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	43
4.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	43

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал”-ын -д 3.7-4-т тусгаснаар Төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, бусад холбогдох баримт бичгүүдээс тухайн төслийн гол зорилт, цар хүрээ, хэмжээ, төсөл хэрэгжих үе шат, түүхий эд, байгалийн баялагийг ашиглалт, эрчим хүч, ус, дулааны хэрэгцээ, техник технологийн сонголт, үйлдвэрлэлийн хүчин чадал, үйлдвэрлэлийн эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, гарах хаягдал, ялгарал, түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам зэргийг тодруулан тусгасан байх шаардлагатай гэсэн дээрх шаардлагуудыг авч үзэв.


Төслийн ерөнхий мэдээлэл

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ	“Ханшашир” ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9019058081 Регистрийн дугаар: 2618176
ТӨСЛИЙН НЭР	“Хайлуур жонш баяжуулах үйлдвэр”
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, 3 оргил хотхон 62-1 тоот Утас: 98008007, 99055718
ТӨСЛИЙН ЗОРИЛГО	Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт орших “Хайлуур жонш баяжуулах үйлдвэр”-ийг барьж байгуулан эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, дүрэм журам, стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулж, улс орон нутагт татвар төлбөрүүдийг төлөх, ордын хүрээлэн буй талбайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх, шинээр ажлын байр бий болгох, ордын үр ашгийг улс, орон нутаг болон төсөл хэрэгжүүлэгч компанид хүртээхэд уг төслийн зорилго оршино.
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР	“Ханшашир” ХХК-нь MV-016819 дугаар бүхий 98.37 га, талбайг ашиглах ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгөөр Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж байна.

1.2 Төслийн байршил

“Хайлуур жонш баяжуулах үйлдвэр” нь Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт оршдог. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш 420 км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос 100 км, Баян-овоо сумын төвөөс баруун зүгт 20-25 км зайд байрладаг.

Зураг 1. Талбайн байршлын зураг



Хүснэгт 1. Талбайн булангийн цэгийн солбицол

1.3 Баяжуулах үйлдвэрийн зохион байгуулалт

“Ханшашир” ХХК-ийн жоншны баяжуулах үйлдвэр нь жоншны хүдрийн физик хими шинж буюу эрдсийн гадаргуу усанд “норох ба үл норох” чанарт үндэслэгдсэн флотацийн аргаар баяжуулагдана. Энэ технологи нь нарийн нунтаглагдсан хүдрийг урвалжийн тусламжтайгаар хөөсрүүлэлт үүсгэн ашигт эрдсийг хөөсөнд наалдуулан ялган авч хоосон чулуулгийг машины камерт үлдээж ялгах зарчимд тулгуурлана.

Баяжуулах үйлдвэр нь ашиглалтын лицензтэй, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй талбайгаасаа хүдрээ хангана. Буталсан хүдэр бункерээс туузан дамжуулагчаар бөмбөлөгт тээрэмд орж, 65-85% нь 200 меш болтол нунтаглагдсаны дараа хөвүүлэн баяжуулалтад орно. Жоншны хүдэр баяжуулах технологид техникийн сод, шингэн шил, олеат натри, нарсны тос зэрэг урвалжуудыг ашиглана.

Тус жоншны баяжуулах үйлдвэрт жилд 38.58% дундаж агуулгатай 50000 тн жоншны хүдрийг флотацийн баяжуулалтаар 95.77%-ийн агуулгатай 19241.6 тн баяжмал авч 2.8%-ийн агуулгатай 30758.39 тн хаягдал ялгана.

Жоншны хүдэр баяжуулах үйлдвэр нь дараах шат дамжлагуудаас бүрдэнэ.

Үүнд: Хүдэр баяжуулалтад бэлтгэх хэсэг

Нунтаглан баяжуулах хэсэг

Урвалжийн хэсэг

Шүүн хатаах, савлах хэсэг зэрэг технологийн үндсэн шат дамжлагуудаас бүрдэнэ.


Баяжуулах үйлдвэр нь жилд хавар 4 сарын 1-ээс өвөл 10 сарын 17 хүртэл тасралтгүй 166 хоног ажиллах бөгөөд 2 ээлж 12 цагаар ажиллана. Бусад үед нь засвар үйлчилгээ хийнэ.

Хүснэгт 2. Баяжуулах үйлдвэрийн ажиллах горим

Хүдэр бутлах цехийн ажиллах горим	Тоон утга
Жилийн хуанлийн өдрийн тоо	365
Жилийн хуанлийн сар	12
Жилийн хуанлийн цаг	8760
Өдрийн хуанлийн цаг	24
Цаг ашиглалт, %	83
Өдөрт ажиллах бодит цаг	24
Сард ажиллах бодит цаг	332
Жилд ажиллах бодит цаг	3984
Жилд ажиллах бодит хоног	166
Цагийн хүчин чадал, тн/цаг	16.63
Хоногийн хүчин чадал, тн/хоног	400
Сарын хүчин чадал, тн/сар	9036.14
Жилийн хүчин чадал, тн/ жил	50000

1.4 Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголт

Дожир ордын хүдрийн шинж чанар болон баяжигдах шинж чанарын судалгааны үр дүн мөн адил төстэй ордын технологийн туршилтын тайлан дахь санал болгосон технологийн схемийг харгалзан жоншны хүдэр боловсруулах технологийн схемийг сонгов.



Зураг 2 Жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийн технологийн схем

Жонш баяжуулах флотацийн үндсэн цикл нь үндсэн ба хяналтын флотаци, 6 шатны цэвэрлэгээний флотациас бүрдэнэ.

Үндсэн болон 1-2-р хяналтын флотаци, 1-р цэвэрлэгээний флотацид SF-4, 2-6-р цэвэрлэгээний флотацид SF-2.8 флот машинууд хэрэглэгдэнэ. 1-3-р шатны цэвэрлэгээний флотацийн завсрын бүтээгдэхүүн болон угаалтын шлам нь өтгөрүүлэгчид шүүгдэж үндсэн флотацийн эхний камерт эргүүлэн өгөгдөнө. 6-р цэвэрлэгээний флотацийн хөөсөн бүтээгдэхүүн бэлэн баяжмалын чанарын үзүүлэлтээс хамааран өтгөрүүлэгдэн, шүүгдэж, хатаагдан бэлэн баяжмал болж гарна.

Үндсэн флотацийн камерын бүтээгдэхүүнийг хяналтын флотацид өгнө. Хяналтын флотацийн хөөсөн бүтээгдэхүүн үндсэн флотацид өгөгдөх ба камерын бүтээгдэхүүнийг хаягдлын санд хаяна.

Хүснэгт 3. Баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн нэгдсэн хүснэгт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Марк	Нийт хүчин чадал, кВт/ц
Бутлах цех				
1	Шигшүүр	1	Гулдмайт	-
2	Бункер	1	V=17 м3	-
3	Тэжээгүүр	1	GZG900*1800	1.1
4	Хацарт бутлуур	1	PEF400*600	30
5	Хацарт бутлуур	1	PEX150*750	15*2
6	Конвейер	1	B650, L=30	5.5
7	Шигшүүр	1	SZ1250*2500	5.5
8	Конвейер	1	B650, L=30	5.5
9	Металл мэдрэгч	1	RCYQ-6	4
10	Конвейер	1	B500, L=40	5.5
11	Кран	1	LDA-5T, L=7.95, H=8	8
12	Конвейер	1		2.2
Баяжуулах цех				

13	Бөмбөлөгт тээрэм	1	GM2100*3600	210
14	Мушгиа ангилуур	2	FLG2000	15
15	Ган	2	RJ20	5.5*2
16	Ган	2	RJ15	5.5*2
17	Флотмашин	18	SF-4	15*18
18	Флотмашин	13	SF-2.8	11*13
19	Насос	2	GMZ80-30-80	2*18.5
Шүүн хатаах цех				
20	Насос	2	80YZ80-20	2*11
21	Өтгөрүүлэгч	2	NZ-12	3*2
22	Вакум шүүлтүүр	1	GW-20	5.5
23	Кран	1	LDA-5T, L=12.95, H=7	8
24	Уурын зуух	1	1.4MW	1.5
25	Насос	2	3*3D-НН	7.5*2
26	Насос	2	ISG80-160A	11*2
27	Насос	1	WQ50-15-15	1.5
28	Хатаах зуух	1	1600*10000	7.5
29	Шурган дамжуулагч	1	300*10000	
30	Савлах машин	1	QLTD3(1-2)	2.2
31	Тэжээгч	1	DZ-4	3

Бүтээгдэхүүн гаргалт

Дожир ордыг түшиглэн байгуулагдах баяжуулах үйлдвэр нь жилд 50000 тн хүдэр баяжуулж, флотацийн баяжуулалтаар 95.77%-ийн агуулгатай 19241.61 тн баяжмал авч 2.8%-ийн агуулгатай 30758.39 тн хаягдал ялгана.

Хүснэгт 4. Бүтээгдэхүүн гаргалт

Үзүүлэлтүүд	Х.н	Ажиллах жил			Нийт	
		1 дэхь	2-3 дахь	4 дахь		
Баяжуулах үйлдвэр						
Жилд боловсруулах хүдэр	тн	50000	100000.00	49757.60	199757.6	
Хүдрийн агуулга	%	38.58	38.58	38.58	38.58	
Хүдэр дэх жонш	тн	19288.59	38577.19	19195.08	77060.87	
Флотацийн баяжуулалт	Баяжмалын агуулга	%	95.77	95.77	95.77	95.77
	Баяжмалын эрдэс авалт	%	95.54	95.54	95.54	95.54
	Баяжмалын гарц	%	38.48	38.48	38.48	38.48
	ФФ-95 маркийн баяжмал	тн	19241.6073	38483.21	19148.33	76873.15
Хаягдал гаргалт						
Хаягдлын агуулга	%	2.80	2.80	2.80	2.80	
Хаягдлын гарц	%	61.52	61.52	61.52	61.52	
Хаягдлын хэмжээ	Хуурай хэсэг	тн	30758.39	61516.79	30609.28	122884.46
		м3	11392.00	22783.99	11336.77	45512.76
	Нойтон хаягдал	м3	36557.95	80158.24	36380.73	153096.92

1.7 Баяжуулах үйлдвэрийн туслах аж ахуй

1.7.1 Хаягдлын аж ахуй

Баяжуулах үйлдвэр нь нийт ажиллах хугацаандаа 199757.6 тн хүдэр баяжуулах ба хаягдлын санд 122884.46 тн 45512.76 м³ хаягдал хаягдана. Жилд 11392 м³ 2-р шатны хяналтын флотацийн хаягдал хаягдлын санд орохоор эзлэхүүнийг тооцоолсон ба далангийн өндөр 5-8 м байна.

Далан нь ойр орчимд элбэг тааралдах материал болох элс хайрга шавраар бүрдсэн овоолго барих ба хаягдлын сангийн дотор талбайг HDPE геомембрамаар доторлоно. Далангийн бусад хэсгийг хайрга болон зориулалтын материалаар бэхжүүлнэ.

Тус үйлдвэрийн хаягдал агуулах сан нь булинга хуримтлуулах 1 ба 2-р сан болон эргэлтийн усан сангуудаас бүрдэнэ. Булинга хуримтлуулах 1-р сангийн ус шүүрүүлэх хэсгээр усыг цэвэршүүлэн хуримтлуулах 2-р цөөрөмд шилжүүлж тэндээс эргэлтийн усны цөөрөмд ус хуримтлагдана. Ингэснээр хаягдлын санд цөөрөм үүсгэх усны хэмжээг бууруулна. Жилийн ихэнх хугацаанд ус дахин ашиглах цөөрөмд орж баяжуулах үйлдвэрийн дэргэдэх усны цөөрөмд шилжиж орно. Хаягдлыг өөрийн урсгалаар нь сан хүртэл тээвэрлэж, дараа нь хаях цэгүүдэд насосоор шахна.


Хаягдлын сангийн байршил багтаамж

Хаягдлын аж ахуй нь баяжуулах үйлдвэрээс 0.2 км зайд оршино.

Хүснэгт 5. Хаягдлын сангийн байршил

Д/д	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	111	47	00.84	47	44	11.78
2	111	47	08.67	47	44	17.08
3	111	47	13.93	47	44	12.88
4	111	47	05.50	47	44	08.09

Баяжуулах үйлдвэрийн хаягдлын санг орон нутгаас өгсөн тусгай зөвшөөрөл бүхий талбайд, үйлдвэрээс баруун урагш байгуулахаар төлөвлөсөн ба үйлдвэрээс 0.2 км зайд 40.0 мян м² талбайтай, 200.0 мян м³ эзлэхүүнтэй байна.



Зураг 3. Хаягдлын аж ахуй

1.7.2 Баяжмалын агуулах, автомашинд ачааллах систем

Нунтаг баяжмалыг савлан баяжуулах үйлдвэрээс авто машинаар цементэлж бэлдсэн баяжмалын ил агуулахын төвд тээвэрлэнэ.

Баяжуулах үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүний агуулахууд нь ил талбайд хадгалагдах бөгөөд байгаль орчинд үүсэх тоосжилтоос сэргийлэх үүднээс өндөр төмөр хашаагаар хүрээлэгдсэн байна.

1.7.3 Засвар үйлчилгээний хэсэг

Засвар үйлчилгээний хэсэгт ЖБУ-ийн тоног төхөөрөмжүүдэд төлөвлөгөөний дагуу ээлжит засвар үйлчилгээ хийхийн зэрэгцээ шинээр тоног төхөөрөмж угсрах, аваарын үед шаардлагатай засвар үйлчилгээ гүйцэтгэнэ. Засвар үйлчилгээний хэсэг нь 9х38м талбайтай, 5м өндөртэй, өргөх кранаар хангагдсан байна. Механик, цахилгааны төхөөрөмжийн засварын хэсэг болон өргөн хэрэглээний засварын 2 албатайгаар зохион байгуулна. Эдгээр өрөөний шал нь бетон цутгамал байна.

1.7.4 Удирдлагын өрөө

Баяжуулах үйлдвэрийн удирдлагын өрөө дараах тоног төхөөрөмжөөс бүрдэнэ.

- Хөдөлгүүрийн хяналтын хэсэг
- Гал илрүүлэгч болон заагч хэсэг
- Хяналтын системийн хэсэг

- Шилэн кабелийн холболтын хэсэг
- Телефон утасны хуваарилах хэсэг

ЖБҮ-ийн удирдлагын өрөө нь угсармал хэв маягтай зөөврийн буюу хөдөлгөөнгүй бэхэлсэн барилга байгууламж байж болно. Удирдлагын өрөө нь битүүмжлэгдсэн байх ба байшинд нэвтрэн орох тоосжилтын хэмжээг бууруулах салаалсан агаар шүүгчтэй байна.

Салаалсан агаар шүүгчийн нэгжүүд нь өрөөний дотоод температурыг 25°C-ээс доош байлгах үүрэгтэй. Доод хэсэгт кабелийг хүргэх үүднээс удирдлагын өрөөний зөөврийн танхимууд нь ган биет бүтцээр газрын түвшнээс доод тал нь 2.1м өндөрт өргөгдсөн байна. Удирдлагын өрөө нь тоног төхөөрөмжийн хэсэгт нэвтрэх давхар хаалга, ажиллагсад нэвтрэх дан хаалга бүхий 2 хаалгатай байна.

1.8 Баяжуулах үйлдвэрийн инженер хангамж

1.8.1 Цахилгаан хангамж

Цахилгаан эрчим хүчний хэрэгцээг Батноров 35/10 кВ дэд станцаас салбарлуулан 31 км агаарын шугам татаж төслийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдэх боломжтой гэж үзэж байна. Шугамын төгсгөлд 10/0.4 кВ-ын дэд өртөө угсран ашиглалтанд оруулна.

1.8.2 Харилцаа холбоо ба мэдээллийн хангамж

Дотоод кабель холболт, телефон утасны гарцыг ЖБҮ-ийн хөдөлгүүрийн удирдлагын төвийн өрөө бүрд суурилуулна (үүнд зорчих машин механизмыг оруулахгүй). Хуваарилах байгууламжийн хяналт, мэдээллийн системд зориулан дотуур холбоог шилэн кабелиар холбоно. Талбайн хэмжээнд олон улсын холбоо харилцаанд шилэн кабель ашиглаж байгаа тохиолдолд доод тал нь 24 гол кабелийг холбоно. Тоног төхөөрөмжийн бие даасан хэсгүүдэд холбогдох бие даасан кабелиуд нь 2 жилийн нөөц буюу 20% нөөцтэй байна.

1.8.3 Хяналтын кабелийн систем (CCTV)

Үйлдвэрийн үйл ажиллагааг алсаас хянах үүднээс CCTV системийг суурилуулна. PC-д суурилсан системээр камеруудыг хянана. Камераас хяналтын өрөө хүртэлх холболтыг шилэн кабелиар хийнэ. Дижитал юм уу аналог камер байж болно. Камер нь IP хаяг оноож болохуйц байх ба дотоод сүлжээгээр харилцана.

Хяналтын системийн гэрэлтүүлэг хангалттай гэрэлтүүлэг үүсгэж чадахгүй бол харагдацыг өдрийн цагийн харагдацаар хязгаарлана. Нэрлэсэн байршил нь:

✓ Нүүрс хүлээн авах бункерт	1
✓ НБҮ-ийн үндсэн процессын хэсэгт	2
✓ Хаягдлын бункерт	1
✓ Овоолгын зөөврийн машинд	1
✓ Бункераас ачаа зөөх хэсэг	2

1.9 Төслийн эдийн засгийн үр ашиг

1.9.1 Хайлуур жоншны хэрэглээ

Дэлхийн хэмжээнд хайлуур жоншийг металлургийн зориулалттай /60-96%-ийн CaF₂-ийн агуулгатай/, хүчлийн зориулалттай хайлуур жоншны бүтээгдэхүүн /+97%-ийн CaF₂-ийн агуулгатай/ гэсэн үндсэн хоёр ангилалаар үйлдвэрлэдэг. Металлургийн зориулалттай хайлуур жоншны бүтээгдэхүүний үндсэн хэрэглээ нь ган хайлуулах үйлдвэрт металлын хайлах температурыг бууруулж, хайлш, шаар ялгарах процессыг түргэсгэх, цементийн үйлдвэрт шатаах зуухны температурыг бууруулах, шохойжих процессыг идэвхжүүлдэг шинжүүд юм.

Хүчлийн зориулалттай хайлуур жоншны бүтээгдэхүүн нь хэрэглээний дийлэнх хэсгийг эзэлдэг бөгөөд хэрэглээ нь:

- Хөнгөн цагааны үйлдвэрлэлд фторт хөнгөн цагаан/AlF₃-г ашигладаг.
- Хүчиллэг фтор/HF/-ын үйлдвэрлэл /флюоритын гаралтай химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь нийтдээ хүчиллэг фторыг ашигладаг бөгөөд хэрэглээг нь дурдвал:
 - Фторт нүүрстөрөгчийг хөргөгч хий, хөргүүр төхөөрөмжийн үйлдвэрлэлд
 - Цахилгаан, электроникийн төхөөрөмж, хагас дамжуулагч үйлдвэрлэхэд
 - Литийн ба терейн үйлдвэрлэлд
 - Сайн чанарын полимер, хөдөө аж ахуйн зориулалттай химийн бодисын үйлдвэрлэлд
 - Нефть-химийн үйлдвэрлэлд урвалыг хурдасгагч болгон хэрэглэдэг байна.

Мөн лабораторийн оптик багажны линзэнд флюоритыг ашигладаг.

1.9.2 Хайлуур жоншны нийлүүлэлт буюу үйлдвэрлэл

АМГТГ-ын мэдээллийн сангийн бүртгэлд 2019 оны 6 сарын 5-ны өдрийн байдлаар нийт 2983 хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл байгаагаас 1682 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүртгэлтэйгээс жоншны 182 ашиглалтын тусгай зөвшөөрөл байна. Монгол орны жоншны нөөц хүдрээр 74 сая тонн эрдсээр 30.2 сая тонн байгаа бөгөөд өнөөгийн байдлаар, “Монголросцветмет” ХХК-ийн Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэр, “Монголчехметалл” ХХК-ийн Чулуутцагаан дэл, Тэвшийн баяжуулах үйлдвэр болон Айраг, Хажуу-Улаан, Өргөн зэрэг хайлуур жоншны 20 үйлдвэр байгаагаас 9 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, бусад аж ахуйн нэгжүүд зөвхөн баяжуулах үйлдвэр барьж ашиглалтад оруулаад байгаа юм. 2019 оны эхний хоёр сарын үзүүлэлтээр жоншны экспорт 49 хувиар өсөж, 23.3 сая ам.долларт хүрсэн байна. Экспортын 70 хувийг БНХАУ, 28.7 хувийг ОХУ, үлдсэн 1.3 хувийг нь БНСУ-д нийлүүлсэн байна. Харин 2018 оны хэмжээнд биет хэмжээгээр экспортолсон жоншны хэмжээ 74 хувиар өсөж, 555.2 мянган тонн болсон үзүүлэлттэй.

1.9.3 Бүтээгдэхүүний үнэ

Манай улсад 20 баяжуулах үйлдвэр ажиллаж байгаагийн дотор толгойлогч үйлдвэр Монголросцветмет нэгдэл бөгөөд нийт үйлдвэрлэлийн 1/3-ийг хангадаг юм. 2018 он гарснаар дэлхийн зах зээлд хайлуур жоншны үнэ огцом өссөн бөгөөд энэ оны 4-р сарын байдлаар 97 хувийн агуулагатай флюоритын баяжмал 415\$ USD байна

1.9.10 Борлуулалтын орлого

Хүснэгт 6. Борлуулалтын орлогын хураангуй

Ашиглалтын жил	ФФ-95 маркийн баяжмалын үнэ		ФФ-95 маркийн баяжмалын үнийг 95.77%-н жоншны агуулгаар хувьчилж тооцсон үнэ, 1тн/төг	Борлуулах баяжмалын хэмжээ, тн	Борлуулалтын орлого, сая.төг
	1тн/юань	1тн/төгрөг			
1	2100	826,098.00	832,793.74	19,241.61	16,024.29
2				19,241.61	16,024.29
3				19,241.61	16,024.29
4				19,148.33	15,946.61
Нийт				76,873.15	64,019.48

1.9.11 Төслийн мөнгөн урсгал, эдийн засгийн үр ашиг

Үйлдвэрийн эдийн засгийн үр ашгийн тооцоогоор татварын өмнөх ашиг жилд дунджаар 5,989.5 сая төгрөг, цэвэр ашиг жилд дунджаар 5,392.2 сая төгрөг, бэлэн мөнгөний урсгалын үнэлгээнд ашиглалтын эцэс дэх үндсэн хөрөнгийн үлдэгдэл өртгийг орох мөнгөн урсгалаар нь үнэлэн ашиглалтын сүүлийн жилд тусгасан. Бэлэн мөнгөний урсгал жилд дунджаар 4,778.3 сая төгрөг, ашиглалтын нийт хугацаанд 19,113 сая төгрөг гарч байна.

Төсөлд 8,152.6 сая төгрөгийн хөрөнгө оруулж, төслийн нийт хугацаанд 21,547 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллана. Төслийн өнөөгийн үнэ цэнийн хорогдуулалтын нормыг 10% -иар тооцож үзэхэд NPV /10%/ 6,993.85 төгрөг, дотоод өгөөжийн норм 46 %, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.71 жил байна.

Хүснэгт 7. Эдийн засгийн үр ашгийн тооцоо

№	Үзүүлэлтүүд	Х.н	Ашиглалтын жилүүд				Нийт
			1	2	3	4	
1	Боловсруулах хүдрийн хэмжээ	тн	50000	50000	50000	49757.6	199757.60
2	ФФ-95 маркийн баяжмалын хэмжээ	тн	19241.6	19241.6	19241.6	19148.3	76873.15
3	ФФ-95 маркийн 1тн баяжмалын үнэ	сая.төг/тн	0.833	0.833	0.833	0.833	0.833
4	Нийт борлуулалтын орлого	сая.төг	16024.3	16024.3	16024.3	15946.6	64019.48
5	Үйл ажиллагааны нийт зардал	сая.төг	6997.6	6997.6	6997.6	6977.2	27970.15
6	Жоншны хүдэр олборлох зардал	сая.төг	2138.3	2138.3	2138.3	2127.9	8542.88
7	Цалин, НДШ-н зардал	сая.төг	1352.8	1352.8	1352.8	1352.8	5411.20
8	Удирдлагын зардал	сая.төг	68.3	68.3	68.3	68.3	273.36
9	Элэгдэл хорогдлын шимтгэл	сая.төг	630.6	630.6	630.6	630.6	2522.51
10	Сэлбэг хэрэгслийн зардал	сая.төг	29.2	29.2	29.2	29.2	116.69
11	Дугуй, түлш, тосолгооны зардал	сая.төг	200.0	200.0	200.0	200.0	800.00
12	ХАБЭА-зардал	сая.төг	115.4	115.4	115.4	115.4	461.41
13	Цахилгааны зардал	сая.төг	520.3	520.3	520.3	517.6	2078.42
14	Материалын зардал	сая.төг	975.5	975.5	975.5	970.8	3897.25
15	Кемпийн зардал	сая.төг	60.0	60.0	60.0	60.0	240.00
16	Баяжмал тээвэрлэх зардал	сая.төг	665.2	665.2	665.2	662.6	2658.36
17	Бусад тооцогдоогүй зардал	сая.төг	242.0	242.0	242.0	242.0	968.07
18	Татвар төлбөрүүд	сая.төг	1805.7	1805.7	1805.7	1797.1	7214.10
19	Ашигт малтмал нөөц ашигласны төлбөр /5%+3.5%/	сая.төг	1729.5	1729.5	1729.5	1721.1	6909.68
20	Автомашин, ө.я хэрэгслийн албан татвар	сая.төг	0.5	0.5	0.5	0.5	2.00
21	Үл хөдлөх хөрөнгийн татвар	сая.төг	26.3	26.3	26.3	26.3	105.22
22	Ус ашигласны төлбөр	сая.төг	20.5	20.5	20.5	20.4	81.89
23	Гаалийн хураамж	сая.төг	28.9	28.9	28.9	28.7	115.31
24	Бусад зардал	сая.төг	225.9	225.9	225.9	225.9	903.41
25	Байгаль хамгаалах зардал	сая.төг	5.0	5.0	5.0	5.0	20.00
26	Орон нутагт оруулах хандив	сая.төг	30.0	30.0	30.0	30.0	120.00
27	Нөхөн сэргээлт ба уурхайн хаалтын хуримтлал	сая.төг	150.0	150.0	150.0	150.0	600.00

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт орших “Дожир” хайлуур жоншны ордыг түшиглэн байгуулагдах баяжуулах үйлдвэрийн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2023 он

28	Өмнөх жилүүдэд хийгдсэн хайгуулын ажлын зарлал	сая.төг	40.9	40.9	40.9	40.9	163.41
29	Нийт зардал	сая.төг	9029.2	9029.2	9029.2	9000.1	36087.66
30	Татвар өмнөх ашиг	сая.төг	6995.1	6995.1	6995.1	6946.5	27931.82
31	Орлогын албан татвар	сая.төг	848.8	848.8	848.8	836.6	3382.95
32	Цэвэр ашиг	сая.төг	6146.3	6146.3	6146.3	6109.9	24548.86
33	Үйл ажиллагааны мөнгөн урсгал CASH FLOW	сая.төг	6777.0	6777.0	6777.0	10004.7	30335.61
34	Анхны хөрөнгө оруулалт	сая.төг	-8309.3				-8309.26
35	Балансын үлдэгдэл өртөг	сая.төг					3264.24
36	Хуримтлагдах мөнгөн урсгал	сая.төг	-1532.3	5244.7	12021.6	22026.4	22026.35
37	NPV 10%	сая.төг					15377.40
38	NPV 20%	сая.төг					10791.09
39	NPV 30%	сая.төг					7501.40
40	NPV 40%	сая.төг					5063.11
41	NPV 50%	сая.төг					3204.93
42	NPV 60%	сая.төг					1754.72
43	NPV 70%	сая.төг					599.42
44	NPV 80%	сая.төг					-337.55
45	NPV 90%	сая.төг					-1109.42
46	NPV 100%	сая.төг					-1754.12
47	Дотоод өгөөжийн норм IRR	%					76%
48	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил					1.23

1.9.12 Улсын төсөв орон нутгийн төсөв оруулах төлбөр, хураамж

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолсон. Жилд дунджаар 2975.45 сая төгрөг, төслийн нийт хугацаанд 11901.8 сая төгрөгийг улс болон орон нутгийн төсөвт оруулахаар байна.

Хүснэгт 8. Татвар төлбөрүүд

№	Татвар төлбөрүүд	Хэмжих нэгж	Улсын төсөвт	Орон нутгийн хөгжлийн санд	Нийт дүн
1	Ашигт малтмал нөөц ашигласны төлбөр /5%+3.5%/	сая.төг	4836.77	2072.90	6909.68
2	-Автомашин, ө.я хэрэгслийн албан татвар	сая.төг	2.00		2.00
3	-Үл хөдлөх хөрөнгийн татвар	сая.төг	105.22		105.22
4	-Ус ашигласны төлбөр	сая.төг		81.89	81.89
5	Аж ахуй нэгжийн орлогийн албан татвар	сая.төг	3382.95		3382.95
6	Хүн амын орлогын албан татвар	сая.төг	541.12		541.12
7	ЭМ, НДШ	сая.төг	643.62		643.62
8	Орон нутагт оруулах хандив	сая.төг		120.00	120.00
9	Гаалийн хураамж	сая.төг	115.31		115.31
10	Нийт дүн	сая.төг	9627.00	2274.80	11901.80

1.9.13 Усны хэрэглээ зардлын тооцоо

Ажилчдын унд ахуй, баяжуулах үйлдвэр болон нөхөн сэргээлтэд ашиглах усыг тус “Ханшашир” ХХК-ийн тусгай зөвшөөрлийн талбайн баруун урд хэсэгт байрлах өөрийн эзэмшлийн гүний худгаас (Худгийн байршил /111°47'13" 47°44'16" ундрага 6.5 л/сек) авч ашиглана.



Зураг 4.4 Гүний худгийн байршил

Уурхайд нийт 82 хүн, жилд нийт 166 хоног ажиллана. Төслийн ашиглалтын жилүүдэд нийт 142579.2 м³ ус хэрэглэх бөгөөд үүнээс унд ахуйд 1089.0 м³ ус, зам талбайн тоосжилт дарах усалгаанд 800.0 м³, уурхайн нөхөн сэргээлтэд нийт 860.0 м³ ус, технологийн усны хэрэгцээнд 139830.3 м³ ус ашиглагдахаар байна. /Ус хэрэглээний нормыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын дагуу баримтлах нормоор тооцов/.

Хүснэгт 9. Усны зарцуулалтын тооцоо

№	Тодорхойлолт	Усны зарцуулалт					
		Х.н	Ашиглалтын жилүүд				Нийт 4 жилд
		М ³	1	2	3	4	
1	Унд ахуйн хэрэглээний ус	м ³	0.02*82хүн*166хон=272.2	0.02*82хүн*166хон=272.2	0.02*82хүн*166хон=272.2	0.02*82хүн*166хон=272.2	1089.0
2	Зам талбайн тоосжилт дарах усалгаа	м ³	1111*0.002*90=200.0	1111*0.002*90=200.0	1111*0.002*90=200.0	1111*0.002*90=200.0	800.0
3	Нөхөн сэргээлтэд ашиглагдах ус	м ³	--	--	--	43000м ² *5*0.004 м ³ =860	860
4	Технологийн усны хэрэгцээнд /20% нөхөн сэлбэлтээр/	м ³	50000 тн хүдэр баяжуулна. 50000тн*3.5тн/м ³ *20%=35000м ³	50000 тн хүдэр баяжуулна. 50000тн*3.5тн/м ³ *20%=35000м ³	50000 тн хүдэр баяжуулна. 50000тн*3.5тн/м ³ *20%=35000м ³	49757.6 тн хүдэр баяжуулна. 49757.6*3.5тн/м ³ *20%=34830.3м ³	139830.3
5	Жилийн усны хэрэгцээ	м ³	35472.2	35472.2	35472.2	36162.5	142579.2
6	Худгийн ундарга м ³ /жил Ундрага 6.5л/сек	м ³	93225.6	93225.6	93225.6	93225.6	466128.0
7	Худгаас авч болох усны хэмжээг 70 хувиар тооцов	м ³	65257.9	65257.9	65257.9	65257.9	326289.6

Унд ахуйн хэрэглээний ус: Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтын дагуу унд ахуйн хэрэглээний нормыг 1 хүний өдрийн 20 л-ээр тооцож гаргасан¹. Нийт 82 хүн, жилд 166 хоног ажиллана. Унд ахуйд

Хоногт $82 \text{ хүн} * 20.0 \text{ л/хон} = 1.64 \text{ м}^3/\text{хон}$ ус,

Нэг жилд $82 \text{ хүн} * 20.0 \text{ л/хон} = 1.64 \text{ м}^3/\text{хон} * 166 = 272.2 \text{ м}^3$,

төслийн ашиглалтын 4 жилийн хугацаанд нийт 1089.0 м³ ус хэрэглэнэ.

Зам усалгаа: Төслийн ашиглалтын 4 жилийн зам талбайн тоосжилт дарах усалгааг 1м² талбайг нормын дагуу 2 л² усаар услахаар тооцсон. Зам талбайг услахдаа тоосжилт ихээр үүсэх 6-9-р сарын хугацаанд, нэг жилд 90 удаа услахаар тооцсон. Зам талбайн тоосжилтыг бууруулахад

$1111 \text{ м}^2 \text{ талбай} * 2 \text{ л/хон} = 2.2 \text{ м}^3/\text{хон}$ ус,

Нэг жилд $1111 \text{ м}^2 * 90 * 2 \text{ л/хон} = 200.0 \text{ м}^3 * 4 \text{ жил} = 800.0 \text{ м}^3$,

Төслийн нийт ашиглалтын 4 жилийн хугацаанд зам талбайн усалгаанд нийт 800.0 м³ ус хэрэглэнэ.

Нөхөн сэргээлтэд ашиглах ус: Нөхөн сэргээлтийг төслийн үйл ажиллагааны сүүлийн жилд хийхээр төлөвлөсөн. Биологийн нөхөн сэргээлтэд нийт 4.3 га талбайд олон наст ургамал тариална. Олон наст үет ургамлыг 43000 м² буюу 4.3 га талбайд тарих бөгөөд 1 м² талбайг нормын дагуу 4 л усаар услахаар тооцсон. Усалгааг ургамлын ургалтын хугацаанд буюу 6-9-р сарын хугацаанд жилд нийт 5 удаа услах бөгөөд төслийн нийт хугацаанд нөхөн сэргээлтэд 860 м³ ус хэрэглэхээр тооцсон.

Нэг жилд $43000 \text{ м}^2 * 5 * 4 \text{ л/хон} = 860 \text{ м}^3$

Баяжуулах үйлдвэрт ашиглах ус: Төслийн ашиглалтын эхний 3 жилд 50000 тн, 4 дахь жилд 49757.6 тн хүдэр боловсруулан баяжуулна. Ашиглалтын 4 жилийн хугацаанд 139830.3 м³ ус хэрэглэх бөгөөд үүнийг 80 хувийг эргэлтийн усаар, 20 хувийг нөхөн сэлбэлтээр ашиглана. Усны хэрэглээг уул уурхайн салбарын усны нормын дагуу хайлуур жонш, жонш флотацийн аргаар баяжуулахад 3.5 тн/м³ ус хэрэглэхээр тооцсон.

Нийт усны хэрэглээний ус ашиглалтын тооцоог худгийн хүчин чадлын 70 хувиар тооцоход бүрэн хүрэлцээтэй байна.

$166 \text{ хон} * 6.5 \text{ л/сек} * 60 \text{ сек} * 60 \text{ мин} * 24 * 70\% = 65257.9 \text{ м}^3$

Хаягдлын сангийн эргэлтийн усан сангийн нөөц 3000м³ бөгөөд үүнийг төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө **14 хоногийн хугацаанд** дүүргэлтийг хийнэ.

$3000 \text{ м}^3 / 14 \text{ хоног} = 214.28 \text{ м}^3/\text{хоног}$

1.9.14 Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц

Зам харилцаа, холбоо: Төслийн талбай нь Улаанбаатар хотоос зүүн тийш засмал замаар 420 км, Хэнтий аймгийн төв Чингис хотоос сайжруулсан шороон замаар 100 км, Баян-овоо сумын төвөөс баруун зүгт 20-25 км зайд байрлана.

Эрчим хүч: Цахилгаан хангамжийн хувьд Батноров 35/10 кВ дэд станцаас цахилгаан хангамжаа татна.

Усан хангамж: Унд ахуй, баяжуулах үйлдвэр болон нөхөн сэргээлтэд шаардлагатай тохиолдолд зам усалгаанд ус хэрэглэхээр тооцсон. Усны хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний

¹ Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралт

² Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралт /зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм/

³ Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 2 дугаар хавсралт /Ашигт малтмал олборлох, баяжуулах, боловсруулахад хэрэглэгдэх усны норм

худгаас зөөвөрлөн ашиглах бөгөөд 80 хувийг эргүүлэн ашиглах, 20 хувийг нөхөн сэлбэлтээр ашиглана.

Цэвэрлэх байгууламж: Ажилчдын сууцны ойролцоо Евролос ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг /Утас: 70180313, 90938888/ ашиглахаар төлөвлөсөн.

- Eurolos Bio станцын өвөрмөц хэлбэр нь хөрсний түлхэлтэнд тэсвэртэй бөгөөд идэмхий бактериудын үржих нөхцлийг дэмждэг. Ийм станцын ялгаатай нь хэлбэрээ удаан хугацаанд хадгалдаг, ялзрахгүй бөгөөд байнга солих шаардлагагүй. Үүний үр дүнд цэвэрлэгээний үр ашиг 95-98% хүрдэг.
- Eurolos гүний биологийн цэвэрлэх байгууламжийг ямар ч төрлийн хөрсөнд, түүнчлэн гүний усны түвшин өндөртэй газарт суурилуулж болох ба бетонон дэвсгэр хийх шаардлагагүй юм. Евролос БИО-ийн цилиндр хэлбэрийг олон жил туршиж үзсэн бөгөөд энэ нь ачааллыг бүх периметрийн дагуу жигд хуваарилдаг.
- Үйл ажиллагааны зарчим нь маш энгийн. Септик савны цилиндрб гурван камертай биед цэвэрлэх гурван үе шат байдаг. Механик, биологийн болон эмчилгээний дараах үе шат. Цэвэршүүлсэн ус нь ариун цэврийн болон эрүүл ахуйн стандартад бүрэн нийцсэн бөгөөд байгаль орчинд эрсдэл учруулахгүйгээр усыг зайлуулах элемент эсвэл газар доорхи шүүлтүүрийн агааржуулалтын талбайнуудаар хөрсөөр нэмэлт боловсруулалт хийхэд илгээдэг.



Байгаль орчинд ээлтэй техник технологи:

1. Нарны халаалтаар хэрэглээний усыг халаах: Нарны халаалтын системээр хэрэглээний усыг халааж бүрхэг өдөр ус нөөцлөх
2. Хөдөлгөөн мэдрэгч камер ашиглан эрчим хүч хэмнэх: Өмнө нь байнга асдаг байсан гэрэлтүүлгүүдийг эрчим хүч бага зарцуулдаг лед гэрлээр сольж, хөдөлгөөн мэдрэгч асдаг болгосноор үйлдвэрийн хэмжээнд тодорхой хэмжээний зардалыг хэмнэх
3. Ахуйн бохир ус цэвэрлэх WSB технологи /”Ультрасоник” ХХК/: Бохир усыг 97 хувь хүртэл цэвэршүүлнэ. Монгол орны эрс тэс уур амьсгалд тохирсон /хөлдөх, удаан хугацаагаар ашиглахгүй тохиолдолд цэвэрлэх процесс хэвийн явагдана.
 - Ашиглалтын зардал багатай
 - Цэвэрлэгдсэн усыг дахин ашиглах боломжтой
 - Хүчилтөрөгчийн ашиглалтыг нэмэгдүүлсэн
 - Өвчин үүсгэгч нянгуудыг микробиологийн аргаар устгана
 - Европын холбооны болон Монгол улсын стандартыг бүрэн хангасан

1.9.15 Техник эдийн засгийн үндэслэл хэсгийн дүгнэлт

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын нутагт орших жоншны хүдэр баяжуулах үйлдвэрийг барьж байгуулахад төслийн анхны хөрөнгө оруулалтын зардал 8.309 тэрбум төгрөг зарцуулахаар байна.

Үйл ажиллагаа явуулах 4 жилийн хугацаанд нийт 199,757.6 тонн хүдрийг флотацийн аргаар баяжуулж 95.54% -ийн эрдэс авалттай 95.77% -ийн агуулгатай ФФ-95 маркийн 76873.15 тн баяжмал экспортод гаргах юм. 95.77% -ийн агуулгатай 1 тонн баяжмалыг 832.794 мянган төгрөгөөр борлуулахад жилд 16.02 тэрбум төгрөгний борлуулалтын орлого хийж, 9.029 тэрбум төгрөгний зардал гаргана. 1 тонн баяжмал үйлдвэрлэх бүрэн өөрийн өртөг нь дунджаар 136.279 мянган төгрөг болно.

Үйлдвэр үйл ажиллагаагаа эхлүүлснээр 82 хүн ажлын байраар хангагдах ба нэг ажилчны сарын дундаж цалин 1,672.05 мянган төгрөг болж байгаа нь орон нутгийн хувьд боломжтой гэж

үзэж байна. Мөн улс болон орон нутгийн төсөвт 4 жилийн хугацаанд 11.901 тэрбум төгрөгийг оруулахаар байгаа нь нийт борлуулалтын орлогын 18.59 %-тай тэнцэж байна.

Төслийн өнөөгийн үнэ цэнэ нь дискаунтын утга 10% байхад 15,377.4 сая төгрөг, дотоод өгөөжийн норм 76%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа нь 1.23 жил байгаа нь төсөл ашигтай болохыг гэрчилж байна.

Дэлхийн зах зээл дээр жоншны эрэлт хэрэгцээ их, үнэ өсөж байгаатай холбогдуулан стандартын шаардлага хангасан жоншны баяжмал үйлдвэрлэн гаргах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа энэ үед “Ханшашир” ХХК-ийн жоншны хүдэр баяжуулах үйлдвэр үйл ажиллагаагаа эхлүүлэх нь эдийн засгийн хувьд үр өгөөжтэй юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Дожирын талбайн физик газарзүй

Уул зүй. Монгол орны газар зүйн мужлалаар тал хээрийн болон Хангайн бүсийн заагт орших учраас гадаргын хувьд намхавтар, нам дов толгодорхог болон нам уулын рельеф зонхилж байдаг. Гадарга нь тэгш оройтой, налуу, хажуутай жигд үргэлжилсэн маягийн толгодтой. Хүдрийн талбайн хувьд үнэмлэхүй өндөр нь далайн түвшинээс дээш 995-1010м байх бөгөөд гадаргын харьцангуй өндөр нь 10-20м байдаг.

Ус зүй. Г адаргуугийн усан сүлжээний хувьд булаг, шанд, хуурай сайруудтай. Түр зуурын урсгал усны нөлөөгөөр үүссэн жалга сайрууд нь гүн биш ховил үүсгэх ба нэг их урт үргэлжилдэггүй. Хуурай сайрууд нь зун болон намрын улиралд усархаг бороо орсны дараа түр хугацааны урсгал устай байх бөгөөд цугларсан ус нь томоохон хөндийнүүдэд шалбааг тойром үүсгэнэ. Энэ нь багавтар хугацаанд тогтоод хур тунадас дахин орж тэжээгдэхгүй бол хатаж ширгэн алга болдог. Ордын орчимд талбайгаас 8км зайтай Хэрлэн гол урсах ба бороотой үед түр зуурын урсгалтай горхи хөндий амууд даган урсдаг.

Уур амьсгал. Ордын нутаг дэвсгэр нь бүхэлдээ эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд хамаарна. Ажиглалтаас үзэхэд цаг уурын температур эрс хэлбэлздэг, хур тунадас багавтар, агаар чийгшилт харьцангуй бага хуурайвтар байдаг. Сарын хамгийн бага дундаж температур нь 1-р сард -22-32°C, хамгийн өндөр дундаж температур нь 7-р сард 20°+25°C байдаг ба дулааны улирал 9-р сар дуустал үргэлжилдэг. Хур тунадас жилд дунджаар 160-180мм хүрнэ. Энд баруун хойноосоо чиглэлтэй салхи зонхилно. Салхины хурд 2.8-7.3м/сек хүртэл хурдасч шороон ба цасан шуурга шуурч хүчтэй салхилах болсон.

Хөрсний байдал. Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Талбайн хэмжээнд хүрэн, цайвар хүрэн, бор хүрэн хөрс зонхилох ба голдуу элсэнцэр, шавранцар агуулна. Хужирлаг цайвар шаргал хөрс нь эх газрын нуурын гаралтай шавранцараас тогтоно. Хөрсний ялзмагт үеийн зузаан нь 0.15-0.2м хааяа 0.3- 0.4м хүртэл хэлбэлзэнэ. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн. Ургамлын бүрхэвч бүрдүүлэгч гол нэр төрлийн өвс ургамал нь шивээ, хялгана, хазаар, агь, таана, хөмүүл, шарилж, божмог гэх мэт. Хөрсний бүтэц нь өөрийн тархалт зузаанаараа харилцан адилгүй. Нутаг дэвсгэрийн хэмжээнд ургамлын тархалт сийрэг, хонхор хотгор газрууд, өндөрлөгүүдийн бэл хажуу нам толгодууд нь өвслөг ургамлаар жигд биш бүрхэгдсэн байдаг.

Амьтан ургамлын аймаг. Амьтан ургамлын аймаг болон уур амьсгалын хувьд говь, тал хээрийн аль алиных нь шинжийг агуулсан холимог байдалтай. Ургамлын аймаг харьцангуй сийрэг тачирхан ургасан өвстэй бөгөөд илчлэг, тэжээллэг чанартай байдаг. Энд таана, хөмүүл, ерхөг зэрэг ургамал ургах бөгөөд бороо хур элбэгтэй цаг агаарын тааламжтай нөхцөлтэй үед ургамал харьцангуй сайн өтгөн ургадаг.

Ан амьтны хувьд харьцангуй төрөл зүйлийн хувьд багавтар байдаг. Энд тарвага, зурам, оготно, цагаан зээр, үнэг, хярс, туулай, чоно байхаас гадна жигүүртэн шувуудаас сар, тас, элээ хааяа талын бүргэд байна. Жижиг хорхой шавьж харьцангуй элбэг.

Хүн ам, эдийн засаг дэд бүтэц. Талбайн хувьд зөвхөн шороон замаар бусад суурин газруудтай холбогдох бөгөөд хамгийн ойр Баян-Овоо сум хүртэл 25км, Бэрхийн уурхай хүртэл 55км, аймгийн төв хүртэл 100км байна. Хөрсний зам нь харьцангуй эвдрэл багатай бөгөөд зөвхөн хүчтэй борооны дараа эвдрэх эсвэл өвөл цасан шуурганаар зам хаагддаг. Хүн ихэнхийг буриад, халхчууд бүрдүүлдэг ба хүн амын нягтрал харьцангуй сийрэг. Өнөөгийн байдлаар эдийн засгийн гол тулгуур нь нүүдлийн мал аж ахуй бөгөөд ганц нэгээр ажиллаж буй хайлуур жонш хувиараа олборлогч байдаг.

УБ хотоос аймгийн төв хүртэл хатуу хучилттай засмал замтай. Чингис хотоос Чойбалсан хүртэл сайжруулсан шороон замаар явна. Хамгийн ойр орших төмөр замын өртөө Дорнод аймгийн төмөр замын өртөө болон Бор-Өндөрийн өртөө болно. Өндөр хүчдэлийн шугам дайрч өнгөрдөг. Тухайн дүүрэгт хүн ам нягтрал нь 1кв.м талбайд 0.50.7 хүн ам ноогдож байгаа нь харьцангуй сийрэг болох юм.

Хамгийн ойр хүн ам суурьшсан төв болох Баян-Овоо сум нь 2000 гаруй хүн амтай. Талбайн орчмоор цөөн тооны малчин өрхүүд зундаа нүүдэллэн ирдэг, тэдний өвөлжөө нь холгүй байдаг. Сумын төвд эмнэлэг, шуудан холбоо, дэлгүүр, буудал, халуун ус зэрэг үйлчилгээний газруудтай.

Тус баяжуулах үйлдвэр нь жилд 38.58%-ийн CaF2 -ын дундаж агуулгатай 50.0 мян.тн хүдэр флотацийн баяжуулалтаар 95.77%-ийн CaF2 -ын агуулгатай ФФ-95 маркийн 19241.6 тн баяжмал гарган БНХАУ-ын Эрээн хотод борлуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлсэн арга зүй

“Хайлуур жонш баяжуулах үйлдвэр”-ийн төслийн байгаль орчинд үзүүлэх гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээг хийж, тайланг боловсруулахдаа төсөл хэрэгжих талбайн байгаль орчны өнөөгийн төлөв байдал, ашиглах технологи, ашиглалтын параметрууд, төслийн үйл ажиллагаанд хамаарах хууль эрх зүйн орчин, нийгэмд үзүүлэх эдийн засгийн үр өгөөж зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурлан, Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яамны Сайдын 2014 оны 04 сарын 10-ны өдрийн А-117 дүгээр тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал” байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд өргөн хэрэглэгддэг **магадлан жагсаах** (checklist) аргаар үнэлсэн.

Хүснэгт 10. Нөлөөллийн үнэлгээний систем

Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа	Хамрах хүрээ	Магадлал
10 - Маш их	5 – Байнгын (30- дээш жил)	5 - Олон улсын хэмжээнд	5 - Гарцаагүй
8 – Их	4 - Урт хугацааны (15-30 жил)	4 - Үндэсний хэмжээнд	4 - Өндөр магадлалтай
6 - Дунд	3 - Дунд хугацааны (5-15 жил)	3 - Бүс нутгийн хэмжээнд	3 - Дунд магадлалтай
4 - Бага	2 - Богино хугацааны (0-5 жил)	2 - Орон нутгийн хэмжээнд	2 - Бага магадлалтай
2 - Маш бага	1 - Түр зуурын	1 - Тухайн орчны хэмжээнд	1 - Тохиолдохгүй
0 - Нөлөөлөлгүй			
Хамгийн өндөр оноо 25 болох бөгөөд түүнийг 100 % гэж үзвэл			
>75 % Нөлөөллийн зэрэглэл өндөр			
40 %- 75 % Нөлөөллийн зэрэглэл дунд			
<40 % Нөлөөллийн зэрэглэл бага			

Нөлөөлөл тус бүрт эдгээр хүчин зүйлүүдийг эрэмбэлсний дараагаар үүсэх магадлал ба хор уршиг гэсэн 2 зүйлийн зэрэглэлийг дараах томъёог ашиглан тооцно:

$$\text{Оноо} = (\text{Эрчим} + \text{Үргэлжлэх хугацаа} + \text{Хамрах хүрээ}) \times \text{Магадлал}$$

Онооны зэрэглэлийн хамгийн их утга нь 100 %-тай тэнцүү байна. Байгаль орчны боломжит нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээтэй уялдуулан Их, Дунд, Бага гэж зэрэглэн ангилна.

Хүснэгт 11. Нөлөөллийг үнэлэх

Үнэлгээний хувь	Нөлөөллийн зэрэглэл	Тайлбар
